

ЕБС-ИЙН БАГШИЙН АЖЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Г.Өлзийсайхан*, МУБИС

Abstract

The main purpose of this study is to investigate Mongolian secondary school teachers' satisfaction with teacher-student relations and teacher co-operation by using TALIS survey questions. The SPSS program is used for this research analysis and regression analysis is set for correlation between characteristics of the teacher, teacher-student relations and teacher co-operation. The outcome of the study shows that teachers' working years and school location do not influence on their satisfaction. However, academic degree and gender issues influence on their job satisfaction. The result of the regress analysis shows that the teacher-student relations and teacher co-operation influence on teachers' job satisfaction. According to the relative impact, the positive relationship of teacher and student is higher than teacher co-operation.

Түлхүүр үг

Сэтгэл ханамж, багш, хамтын ажиллагаа

Удиртгал

Багш бол боловсролын хамгийн суурь нэгж болох хичээлийг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх субъект бөгөөд боловсролын чанар, үр дүнгийн хамгийн чухал хувьсагч юм. Тиймээс ч багштай холбоотой мэдээллийг цуглуулж, тэдгээр нь багшлахуйд хэрхэн нөлөөлж буйг судлах нь судлаачдын судалгааны чухал сэдэв байсаар байна. Энд чухлаар тавигддаг асуудлын нэг нь багшийн сэтгэл ханамж юм. Багшийн сэтгэл ханамж нь сургуулиас, багшаас, сурагчдын онцлог, сургуулийн удирдлага зэрэг олон зүйлээс хамаардаг. Мөн сэтгэл ханамж нь багшийн ажлын бүтээмж, чанарт нөлөөлдөг билээ. Олон улсын байгууллагууд ч улс орны багшлах хүний нөөцийн бодлогод ашиглаж болохуйц мэдээллийг цуглуулах, түүнд анализ хийх хэрэгцээ байгаад анхаарч байна. Боловсролтой холбоотой хамгийн өргөн хүрээний мэдээллийг олон улсын түвшинд цуглуулж, харьцуулж нийтэд түгээж байгаа байгууллага бол OECD юм. OECD-ээс хийж буй багштай холбоотой судалгаа бол TALIS юм. TALIS нь сургуулийн захирлын манлайлал, багшийн мэргэжлийн хөгжил, багшийн багшлахуй зэрэг өргөн асуудлыг харьцуулан судалдаг бөгөөд багшийн сэтгэл ханамж ч чухал байр суурийг эзэлдэг.

Манай орны хувьд багшийн сэтгэл ханамжийн судалгаа хувь судлаачийн түвшинд маш өргөнөөр хийгдэж байна. Гэсэн ч багшийн мэргэжлийн сэтгэл ханамж, ажлын сэтгэл ханамжийг тодорхой ялгаагүй эсвэл судалгааны аргын хувьд нэг эсвэл хоёр хувьсагчийн

шинжилгээгээр хийгдэж, хоорондын хамаарлыг гаргасан судалгаа ховор байна. Тиймээс энэхүү судалгаа TALIS судалгааны асуулгыг ашиглан багшийн мэргэжлийн сэтгэл ханамж, ажлын сэтгэл ханамжид нөлөөлж буй хүчин зүйлийг олон хувьсагчийн түвшинд судлахыг Үүний тулд дараах асуултуудыг авч үзлээ. Багшийн мэргэжлийн сэтгэл ханамж, ажлын сэтгэл ханамж нь багшийн онцлогоос хамаарч ялгаатай байна уу? Багшийн мэргэжлийн сэтгэл ханамж, ажлын сэтгэл ханамжид багш-сурагчийн харилцаа, багшийн хамтын ажиллагаа ямар нөлөө үзүүлж байна вэ?

Үндсэн хэсэг

Лок³ (1968) мэргэжлийн сэтгэл ханамж гэдэг нь хувь хүн мэргэжлээсээ олохыг хүссэн зүйл ба бодит байдал хоёрын зааг юм гээд сэтгэл ханамжид дараах зүйлсийг харгалзан үзжээ. Сэтгэл ханамж гэдэг нь чухал гэж үзсэн мэргэжлийн үнэт зүйлийг хувь хүн хэрэгжүүлж чадаж буй эсэхээс шалтгаалан хувь хүний ажлыг үнэлдэг тул багшийн ажлын сэтгэл ханамжид мэргэжлийн нэр хүнд, бахархал, ажил үүргийн чөлөөт байдал, мөн өөрийн мэргэжлийн хөгжил нөлөөлдөг. Сургуулийн шинэчлэлийг манлайлж чадах захирлын манлайлал, багш нар хамтран ажиллах соёл нь багшийн сэтгэл ханамжийг бий болгож, багш өөрийн ажил үүргээ хэр мэдэрч, түүндээ сэтгэл ханамжтай буй эсэхээс боловсролын үр дүн шалтгаалдаг (Bogler, 2001).

* ulziisaikhan@msue.edu.mn

³Lock

Багшийн сэтгэл ханамжид нөлөөлдөг хувьсагчийг багшийн өөрийн онцлог, сургуулийн захирлын онцлог, сурагчдын онцлог зэргээр ангилж болдог (Turner, 2007). Сургуулийн захирал мэдээллээ хуваалцаж, эрх мэдлээ шилжүүлж, багш нартай нээлттэй харилцаатай байх тусам сургуулийн багш нарын сэтгэл ханамж өндөр байдаг (Bogler, 2001). Мөн багшийн мэргэжлийн ажилд илүү их чөлөөт байдлыг олговол багшийн сэтгэл ханамж өндөр байдаг (Hall, Pearson & Carroll, 1992).

Багш нарын хамтын ажиллагаа нь танин мэдэхүй, ёс зүй, улс төр, нийгэм, сэтгэл зүйн ямар ч нөхцөл байдалд хамт ажиллаж буй багш нартайгаа харилцах харилцаа (collegiality), тэдэнтэй хамт хийх танин мэдэхүйн үйл (collaboration)-ийг багтаасан байдаг (Jarzabkowski, 2002). Тиймээс Жарзабковский⁴ (2002) багшийн хамтын ажиллагааг багш хоорондын дэмжлэг ба итгэл, багшлахуйн үйлийн хамтын оролцоо, хамтаар сургалтыг төлөвлөх, үнэлэх, мэдлэг, бодол санаагаа хуваалцах, харилцан суралцах, хамтаар сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хөгжүүлэх, мэдээлэл, нөөцийг хуваалцах үйл гэж тодорхойлжээ. Сургуулийн багш, ажилчид хамтран ажиллах эерэг нөхцөл байдал нь багшийн сэтгэл зүйн ачааллыг багасгах, өөдрөг эерэг уур амьсгалыг бүрдүүлж, ямар нэг бүлгийн гишүүн гэсэн мэдрэмжийг багшид бий болгодог (Madiha, 2011). Мөн мэргэжлийн оролцоо, сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг (Woods et al, 2002) байна.

Женнингс⁵, Грийнберг⁶, (2009) нийгэм-сэтгэл зүйн чадвар өндөр багш нар ажил үүргээ тогтвортой хийхээс гадна сургууль, анги танхимын нөхцөл байдлыг зөв танин, түүндээ тохируулж үйл хийдэг, энэ нь сурагчидтай эерэг харилцааг бүрдүүлэхэд тус болдог гэж үзжээ.

TALIS (2013) судалгаанд багшийн

сэтгэл ханамжийг мэргэжлийн сэтгэл ханамж, ажлын сэтгэл ханамж гэж авч үзсэн байдаг. Энд мэргэжлийн сэтгэл ханамж гэдэг нь багш мэргэжлээс авч буй сэтгэл ханамж, харин ажлын сэтгэл ханамж гэдэг нь ажлын орчноос авч буй сэтгэл ханамжийг авч үзсэн байдаг. TALIS (2013) судалгаанд багшийн сэтгэл ханамжийг судлахдаа Р.М.Классен⁷ ба Чуй⁸, (2010)-ийн загварыг өргөтгөж ашигласан бөгөөд энэ загварт сэтгэл ханамжид нөлөөлдөг хувьсагчаар багш нарын хамтын ажиллагаа, багш-сурагчийн харилцааг авч үзсэн байдаг.

Судалгааны арга зүй, үр дүн

Судалгааны асуулга, түүвэр

Энэхүү судалгаа багшийн ажлын сэтгэл ханамжийг судлахдаа OECD⁹ TALIS¹⁰ 2013 судалгаанд ашигласан санал асуулгыг ашиглалаа. TALIS судалгаа сургуулийн захирал, багшийн мэргэжлийн хөгжил, багшийн үнэлгээ, багшлахуй-суралцахуй, багшийн сэтгэл ханамж зэрэг чиглэлээр дээрх орнуудын бодит байдлыг гаргаж харьцуулах зорилготой бөгөөд, 2013 оны судалгаанд 34 орон хамрагдсан болно.

TALIS судалгаа багшийн сэтгэл ханамжийг судлахдаа мэргэжлийн сэтгэл ханамж (profession satisfaction), ажлын орчны сэтгэл ханамж (work environment satisfaction) гэж ангилан нийт 8 асуултаар гаргасан байдаг. Үүнд мэргэжлийн сэтгэл ханамжийг 5, ажлын сэтгэл ханамжийг 3 асуулт (TT2G46A- TT2G46J)-аар Likert аргаар ‘1=Огт санал нийлэхгүй байна’, ‘2=Санал нийлэхгүй байна’, ‘3=Санал нийлж байна’, ‘4=Маш их санал нийлж байна’ гэж хэмжээсжүүлсэн.

Дээрх асуултауд, тэдгээрт хийсэн фактор анализ, найдвартай байдал (reliability)-ын шинжилгээний үр дүнг Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1

Багшийн ажлын сэтгэл ханамжийн асуулга

Хувьсагчийн нэр	Асуулгын дугаар	Агуулга	Factor loading	Cronbach's Alpha ¹
Мэргэжлийн сэтгэл ханамж	TT2G46D	Би багшийн мэргэжил сонгосондоо харамсдаг.	.660	0.679
	TT2G46F	Би багшаас өөр мэргэжил сонгосон бол илүү сайхан байх байсан гэж боддог.	.660	
	TT2G46J	Би багш мэргэжилдээ ерөнхийдөө сэтгэл ханамжтай байдаг.	.524	
	TT2G46B	Хэрэв мэргэжил дахин сонгох болбол би багш мэргэжлийг сонгоно.	.511	
Ажлын сэтгэл ханамж	TT2G46A	Багш мэргэжилд муу зүйлээс илүү сайн зүйл их байдаг гэж би боддог.	.269	0.659
	TT2G46E	Би энэ сургуульд ажиллахдаа дуртай байдаг.	.775	
	TT2G46G	Би багш нарт манай сургуульд ирж ажиллахыг санал болгоно.	.552	
	TT2G46C	Би боломж олдвол өөр сургууль руу шилжих хүсэлтэй.	.524	

* TT2G46C, TT2G46D, TT2G46F асуултын хариултын утгын тонгоруу утгыг судалгаанд ашиглав.

⁴Jarzabkowski
⁵Jennings & ⁶Greenberg
⁷Klassen, R.M. & ⁸Chiu

⁹Organization for Economic Cooperation and Development
¹⁰Teaching and Learning International Survey

Багш нарын хамтын ажиллагааг Хүснэгт 2-т үзүүлсэн 8 асуулт (ТТ2G33А- ТТ2G33G)-аар тодорхой хугацааны давтамжаар хэмжээсжүүлсэн (1=Огт үгүй, 2=Жилд нэг удаа, 3=Жилд 2-4 удаа, 4=Жилд 5-10 удаа, 5=Сард 1-3 удаа, 6=Долоо хоног бүр). Асуултын найдвартай байдлын зэргийг Хүснэгт-2-т харуулав.

Хүснэгт 2

Багш нарын хамтын ажиллагаа

Хувьсагчийн нэр	Асуулгын дугаар	Агуулга	Factor loading	Cronbach's Alpha
Багш-сурагчийн харилцаа	ТТ2G45С	Манай сургуулийн багш нар сурагчдын дуу хоолой /тэдний ярьж буй зүйл/-г анхааралтай сонсдог.	.662	0.675
	ТТ2G45В	Манай сургуулийн багш нар сурагчдад халамж, дэмжлэг чухал гэж үздэг.	.575	
	ТТ2G45А	Манай сургуулийн ихэнх багш, сурагчид хоорондоо сайхан харилцаатай байдаг.	.575	
	ТТ2G45D	Нэмэлт тусламж, дэмжлэг шаардлагатай сурагчдад манай сургууль тусламж үзүүлдэг.	.454	
Багш нарын хамтын ажиллагаа	ТТ2G33А	Хамтын хичээл заах	.761	0.835
	ТТ2G33В	Бусад багш нарын хичээлд сууж зөвлөгөө өгөх	.756	
	ТТ2G33Н	Мэргэжлийн хамтарсан сургалт, үйл ажиллагаа	.610	
	ТТ2G33Е	Тодорхой нэг сурагч, бүлгийн сургалтын талаарх тусгайлсан хэлэлцүүлэг хийх	.596	
	ТТ2G33С	Өөр анги, бүлгийн хүүхдүүдийг оролцуулсан нийтийн үйл ажиллагаа (жнь: төсөлт ажил).	.563	
	ТТ2G33F	Сургуулийнхаа бусад багш нартай хамтран суралцагчдын явцыг үнэлэх нэгдсэн шалгуур гаргах	.524	
	ТТ2G33D	Бусад багш нартай сургалтын хэрэглэгдэхүүнээ солилцох	.524	
	ТТ2G33G	ЗАН-ын хурал	.413	

Судалгааны түүврийг улсын хэмжээнд хийж нийт 60 сургуулийн багш нарыг хамруулсан. Судалгааны асуулгыг 2017 оны 4 дүгээр сараас 5 дугаар сарын хугацаанд цахим шуудан, цаасан хэлбэрээр авч нэгтгэсэн. Судлаач нийт 400 асуулга илгээснээс 360 асуулга бөглөгдөн ирснээс бүрэн бус хариулттай асуулгыг хасаж, эцсийн байдлаар 336 асуулгыг энэхүү судалгаанд ашиглав (Хүснэгт 3).

Хүснэгт 3

Судалгаанд ашигласан түүврийн мэдээлэл

	Төлөвлөсөн санал асуулгын тоо	Ирүүлсэн тоо	Судалгаанд ашигласан асуулгын тоо
Нийт	400	360 (90%)	336 (84%)

Энэ хүү судалгаанд хамрагдсан түүврийн дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт-4-т харуулав. Нийт түүврийн 78% нь эмэгтэй багш, ажилласан жилийн тархалт нь 5 хүртэлх жил ажилласан багш 30.1%, 62% нь ямар нэг мэргэжлийн зэрэгтэй, 21% нь бага ангийн багш, нийслэлийн багш 47%-ийг эзэлж байна. Багшийн ажлын сэтгэл ханамжийг судлахдаа үүнд онц нөлөө үзүүлэхгүй гэсэн дараах үзүүлэлтүүдийг нэгтгэж судалсан болно. Үүнд: судлагдахууны чиглэлийг бага анги, дунд анги, сургуулийн байршлыг сумын төв, аймгийн төв, хотын төв гэж авч үзсэн.

Хүснэгт 4

Судалгаанд ашигласан түүврийн мэдээлэл

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл		Түүврийн тоо	Хувь
Хүйс	эр	74	22.0
	эм	262	78.0
Ажилласан жил	5 хүртэл	101	30.1
	6-10 жил	66	19.6
	11-15 жил	51	15.2
	16-20 жил	48	14.3
	21 ба түүнээс дээш	70	20.8
Мэргэжлийн зэрэг	Зэрэггүй	128	38.1
	Заах аргач	121	36.0
	Тэргүүлэх	85	25.3
	Зөвлөх	2	0.6
Судлагдахууны чиглэл	Бага анги	72	21.4
	Байгалийн ухаан	128	38.1
	Нийгмийн ухаан	136	40.5
Сургуулийн байршил	Сумын төв	117	34.8
	Аймгийн төв	61	18.2
	Хотын төв	93	27.7
	Хотын зах	65	19.3
Нийт		336	100

Судалгааны арга

Энэхүү судалгаа ЕБС-ийн багшийн сэтгэл ханамж, үүнд багшийн нарын хамтын ажиллагаа, багш-сурагчийн харилцаа хэрхэн нөлөөлдгийг судлах зорилготой. Үүний тулд SPSS 20.0 хувилбарыг ашиглан дараах үе шатаар анализ хийлээ. Юуны түрүүнд TALIS-ийн судалгааны асуулгыг найдварыг Cronbach α шинжүүрээр хийв.

Багшийн сэтгэл ханамжийг мэргэжлийн сэтгэл ханамж, ажлын орчны сэтгэл ханамж гэж ангилан үр дүнг тооцов. Сэтгэл ханамжийн түвшинг багшийн ажилласан жил, ажиллаж буй сургуулийн байршил, мэргэжлийн зэрэг, хүйс, зааж буй судлагдахуун зэргээр харьцуулан t тест, F тестээр анализ хийж, шаардлагатай үед аль бүлгүүдийн хооронд ялгаа байгааг мэдэхийн тулд Scheffe шинжүүрийг давхар ашиглав. TALIS (2013) судалгаанд авч үзсэний дагуу багшийн мэргэжлийн сэтгэл ханамж болон ажлын орчны сэтгэл ханамж, багш нарын хамтын ажиллагаа, багш-сурагчийн харилцаа хоорондын хамаарлыг судлахын тулд регресс шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүн

Мэргэжлийн болон ажлын орчны сэтгэл ханамж хүйсээр ялгаатай эсэхийг t шинжүүрээр шинжиллээ. Үр дүн нь мэргэжлийн сэтгэл ханамжид хүйс нөлөөлдөггүй, харин ажлын орчны сэтгэл ханамжид хүйс нөлөөлж байна. Өөрөөр хэлбэр эрэгтэй багшийн ажлын орчны сэтгэл ханамж эмэгтэй багшийнхаас өндөр байна. Мэргэжлийн сэтгэл ханамж нь ажлын орчны сэтгэл ханамжаас өндөр гарсан байна.

Хүснэгт 5

Мэргэжлийн сэтгэл ханамжийн түвшин /хүйсээр/

	Хүйс	Дундаж	Стандарт хазайлт	t утга
Мэргэжлийн сэтгэл ханамж	Эр	3.46	0.45	1.106
	Эм	3.40	0.43	
	Бүгд	3.42	0.44	
Ажлын орчны сэтгэл ханамж	Эр	3.43	0.47	2.047*
	Эм	3.30	0.53	
	Бүгд	3.33	0.52	

* $p < 0.05$, ** $p < 0.01$, *** $p < 0.001$

Мэргэжлийн сэтгэл ханамжийн түвшинг багшийн ажилласан жил, мэргэжлийн зэрэг, судлагдахуун, сургуулийн байршлаар авч үзсэн үр дүнг дор харуулав. Хүснэгт-6-аас харахад багшийн мэргэжлийн сэтгэл ханамжийн түвшинд мэргэжлийн зэргээс хамаарч ялгаатай гарч байна. Өөрөөр хэлбэл багшийн мэргэжлийн зэрэг өсөх тусам ажлын орчны сэтгэл ханамж өндөр гарч байна.

Хүснэгт 6

Мэргэжлийн сэтгэл ханамжийн түвшин /багшийн онцлогоор/

		Дундаж	Стандарт хазайлт	F, t утга
Ажилласан жил	5 хүртэл жил (a)	3.42	0.43	1.704
	6-10 жил (b)	3.34	0.39	
	11-15 жил (c)	3.41	0.45	
	16-20 жил (d)	3.35	0.48	
	21 ба түүнээс дээш(e)	3.52	0.44	
Мэргэжлийн зэрэг	Зэрэггүй (a)	3.41	0.43	3.440* b<c
	Заах аргач (b)	3.35	0.45	
	Тэргүүлэх зөвлөх (c)	3.51	0.44	
Судлагдахуун	Бага анги (a)	3.44	0.44	0.504
	Дунд анги (b)	3.41	0.43	
Сургуулийн байршил	Сумын төв (a)	3.48	0.44	2.199
	Аймгийн төв (b)	3.35	0.42	
	Нийслэл (c)	3.39	0.44	

* p<0.05, ** p<0.01, *** p<0.001

Ажлын орчны сэтгэл ханамжийн түвшинг багшийн ажилласан жил, мэргэжлийн зэрэг, судлагдахуун, сургуулийн байршлаар авч үзсэн үр дүнг дор харуулав. Хүснэгт-7-оос харахад ажилласан жилээс хамаарч ажлын орчны сэтгэл ханамж ялгаатай гарч байна. Өөрөөр хэлбэл 6-15 жил ажиллахад багшийн сэтгэл ханамж өндөр байдаг бол 16-20 жилд буурч ирснээ 21 жилээс дахин нэмэгддэг болох нь харагдаж байна. Харин бусад үзүүлэлтийн хувьд ажлын орчны сэтгэл ханамжид нөлөөлдөггүй байна.

Хүснэгт 7

Ажлын орчны сэтгэл ханамжийн түвшин

		Дундаж	Стандарт хазайлт	F утга
Ажилласан жил	5 хүртэл жил (a)	3.24	0.53	3.388*
	6-10 жил (b)	3.34	0.49	
	11-15 жил (c)	3.42	0.50	
	16-20 жил (d)	3.26	0.51	
	21 ба түүнээс дээш(e)	3.45	0.52	
Мэргэжлийн зэрэг	Зэрэггүй (a)	3.33	0.52	0.470
	Заах аргач (b)	3.39	0.47	
	Тэргүүлэх, зөвлөх (c)	3.36	0.56	
Судлагдахуун	Бага анги (a)	3.29	0.60	-1.208
	Дунд анги (b)	3.38	0.48	
Сургуулийн байршил	Сумын төв (a)	3.39	0.46	1.356
	Аймгийн төв (b)	3.34	0.59	
	Нийслэл (c)	3.28	0.53	

Мэргэжлийн сэтгэл ханамжийн регрессийн загвар $F=6.929$ ($p<0.000$) буюу ач холбогдолтой гарч, тайлбарлах чадвар 11% ($R^2=.112$) байна. Tolerance утга 1-ээс доош утга авдаг ба 1-т ойр утга авбал хувьсагчууд хоорондоо хамааралгүй гэж үздэг.

Багш-сурагчийн харилцаа болон багш нарын хамтын ажиллагаа багшийн мэргэжлийн сэтгэл ханамжид эерэг нөлөөлдөг, өөрөөр хэлбэл бусад хувьсагчуудыг хянаж чадсан үед багш-сурагчийн

харилцаа 1 нэгж өсөхөд мэргэжлийн сэтгэл ханамж 0.245 нэгж, хамтын ажиллагаа 1 нэгж өсөхөд 0.069 нэгж өсдөг байна. Багшийн хүйс, мэргэжлийн зэрэг, сургуулийн байршлыг дамму¹¹ хувьсагчаар оруулсан бөгөөд мэргэжлийн зэрэг л статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлсэн гарч байна. Өөрөөр хэлбэл зэрэгтэй багшийн сэтгэл ханамж өндөр байна.

Хүснэгт 8

Мэргэжлийн сэтгэл ханамж

Хувьсагч	Стандарт бус коэффициент		β	t	Tolerance
	В утга	Хазайлт			
Constant	2.264	.195		11.598***	
Багш-сурагчийн харилцаа	.245	.065	.218	3.754***	.800
Багш нарын хамтын ажиллагаа	.069	.031	.130	2.213*	.780
Хүйс (эр=1, эм=0)	.076	.055	.072	1.377	.980
Мэргэжлийн зэрэг (зэрэгтэй=1, зэрэггүй=0)	.087	.030	.157	2.913**	.924
D1	.074	.052	.081	1.425	.839
D2	-.048	.063	-.042	-.761	.872

* p<0.05, ** p<0.01, *** p<0.001
D1: сумын төв=1, бусад нь =0, D1: аймгийн төв=1, бусад нь =0

Багшийн ажлын орчны сэтгэл ханамжийн регрессийн загвар $F=15.484$ ($p<0.000$) буюу статистикийн ач холбогдолтой гарч, тайлбарлах чадвар 22% ($R^2R^2=.220$) байна. Регрессийн загварт орсон үл хамаарах хувьсагчуудын хооронд хамаарал байгаа эсхийг Tolerance утгаар шалгахад хамаарал гарсангүй.

Ажлын орчны сэтгэл ханамжид багш-сурагчийн харилцаа, багш нарын хамтын ажиллагаа, мэргэжлийн зэрэг эерэг нөлөө үзүүлдэг байна. Өөрөөр хэлбэл багш-сурагчийн харилцаа, багш нарын хамтын ажиллагаа сайн байх тусам багшийн ажлын орчны сэтгэл ханамж өндөр байдаг байна. Мэргэжлийн зэргийн хувьд зэрэгтэй багш зэрэггүй багшаас сэтгэл ханамж өндөр гарч байна. Хүйс ажлын сэтгэл ханамжид нөлөөлж байгаа буюу эрэгтэй багшийн сэтгэл ханамж илүү өндөр гэж гарч байна. Энэ нь Хүснэгт-5-д гарсан үр дүнг бататгаж байна. Регрессийн стандарт коэффициент буюу β утга нь үл хамаарах хувьсагчид хамаарах хувьсагчид нөлөөлөх нөлөөг харьцангуй байдлаар харуулдаг тул багш-сурагчийн эерэг харилцаа багшийн ажлын орчны сэтгэл ханамжид илүү их нөлөө үзүүлдэг байна.

Хүснэгт 9

Ажлын орчны сэтгэл ханамж

Хувьсагч	Стандарт бус коэффициент		β	t	Tolerance
	В утга	Хазайлт			
Constant	1.337	.216		6.183***	
Багш-сурагчийн харилцаа	.502	.072	.378	6.953***	.800
Багш нарын хамтын ажиллагаа	.084	.034	.134	2.435*	.780
Хүйс	.141	.061	.113	2.296*	.980
Мэргэжлийн зэрэг	.091	.033	.140	2.758**	.924
D1	.065	.058	.060	1.129	.839
D2	.041	.070	.030	.583	.872

* p<0.05, ** p<0.01, *** p<0.001

¹¹Dummy

Дүгнэлт

Энэхүү судалгаа TALIS судалгааны асуулгыг ашиглан багшийн сэтгэл ханамж, сургуулийн багш-сурагчийн харилцаа, багш нарын хамтын ажиллагаа хоорондын хамаарлыг судлах зорилготой. Үүний тулд багшийн сэтгэл ханамжийг мэргэжлийн сэтгэл ханамж, ажлын орчны сэтгэл ханамж ангилан судаллаа. Судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Багшийн мэргэжлийн сэтгэл ханамж нь өндөр гарсан бөгөөд багшийн хүйс, мэргэжлийн зэрэг, ажилласан жил, судлагдахуун, сургуулийн байршлаас хамаарч ямар нэг ялгаа гарсангүй. Өөрөөр хэлбэл манай улсын багш нар багш мэргэжилдээ сэтгэл ханамж нэгэн ижил өндөр байна. Багшийн ажлын орчны сэтгэл ханамжийг судалж үзэхэд мөн өндөр гарч байна. Энэ нь багшийн хувийн онцлогоор ялгаатай эсэхийг авч үзэхэд ажилласан жил, судлагдахуун, сургуулийн байршлаас үл хамаарч нэгэн ижил байна. Харин хүйсээр авч үзэхэд эрэгтэй багшийн сэтгэл ханамж өндөр, тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй байх тусам заах аргач зэрэгтэй багшаас сэтгэл ханамж өндөр гарч байна. Ажилласан жил мэргэжлийн зэрэг хоорондоо хамааралтай байж болох ч мэргэжлийн зэргээс шалтгаалан сэтгэл ханамж ялгаатай гарч байна.

Багшийн мэргэжлийн сэтгэл ханамж, ажлын орчны сэтгэл ханамжийг сургуулийн багш-сурагчийн харилцаа, багш нарын хамтын ажиллагаанаас хамааруулан судалж үзэхэд эерэг нөлөө үзүүлж байна. Регрессийн шинжилгээнээс харахад багшийн сэтгэл ханамжид багш нарын хамтын ажиллагаанаас илүү багш-сурагчийн харилцаа харьцангуй их нөлөө үзүүлдэг гарч байна. Гэсэн хэдий ч сургууль, багш багш-сурагчийн эерэг харилцааг бүрдүүлж, сурагчдын санал бодлыг сонсож ажиллах, багш нарын хамтын ажиллагааг өргөн хүрээнд олон чиглэлээр хамтарч ажиллах орчин бүрдүүлж, давтамжийг нэмэгдүүлэх нь нь багш сэтгэл ханамжтай ажиллахад чухал нөлөө үзүүлэх юм.

Ашигласан материал

OECD (2014). *TALIS 2013 result. An international perspective on teaching and learning*. Paris, France: OECD.

Crossman, A. and P. Harris (2006), "Job satisfaction of secondary school teachers", *Educational Management Administration and Leadership*, 34, 29-46.

Darling-Hammond, L. and N. Richardson (2009), "Teacher learning: What matters?", *Educational Leadership*, 66(5), 46-53.

Judge, T.A. et al. (2001), "The job satisfaction-job performance relationship: A qualitative and quantitative review", *Psychological Bulletin*, 127(3), 376-407.

Klassen, R.M. and M.M. Chiu (2010), "Effect on teachers' self-efficacy and job satisfaction: Teacher gender, years of experience, and job stress". *Journal of Educational Psychology*, 102(3), 741-756.

Locke, E. (1968), "What is job satisfaction?" *Organizational Behavior and Human Performance*, 4(4), 309-336.

Wininger, S.R. and P.M. Birkholz (2013), "Sources of instructional feedback, job satisfaction, and basic psychological needs", *Innovative Higher Education*, 38, 159-170.

Firestone, W. A., Pennell, J. R. (1993). Teacher commitment, working conditions, and differential incentive policies, *Reviews of Educational Research*, 63(4), 489-525.

Woods, A. M., Weasmer, J. (2002). Maintain job satisfaction: Engaging professionals as active participants, *The Clearing House*, 75(4), 186-189.

Hall, B. W., Person L. C., Caroll, D. (1992). Teachers' long-range teaching plans: a discriminant analysis, *Journal of Educational Research*, 85(4), 221-225.

Jarzabkowsk, L. M. (2002). The social dimensions of teacher collegiality, *Journal of Educational Inquiry*, 3(2), 1-20.

Mdiha shah. (2011). The dimensionality of teacher collegiality and the development of teacher collegiality scale, *International Journal of Education*, 3(2), 1-20.

Bogler, R. (2001). The influence of leadership style on teacher job satisfaction. *Educational administration quarterly*, 37(5), 662-683.

Tuner, H.(2007). *Predictors of Teachers' Job Satisfaction in Urban Middle Schools*. Doctoral dissertation. University of North Carolina at Chapel Hill.